210301	Гэрэл, цахилгаан	1,962,500.00	1,896,149.27	1,962,500.00	2,066,161.50
210302	Түлш, халаалт	15,767,400.00	18,337,864.00	50,265,600.00	50,108,445.00
210303	Цэвэр, бохир ус	434,300.00	190,000.00	434,300.00	156,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,188,000.00	22,894,450.00	25,702,700.00	23,137,331.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00	2,984,800.00	2,874,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,167,000.00	17,873,350.00	18,836,900.00	16,828,991.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	621,000.00	621,000.00	621,000.00	546,800.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00	60,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00	1,200,000.00	1,472,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,100.00	2,000,000.00	1,415,540.00
2105	<b>Нормативт зардал</b>	40,562,000.00	42,644,285.73	53,061,900.00	40,256,047.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,000,000.00	30,300,805.73	40,499,900.00	32,343,027.00
210502	Хоол, хүнс	10,062,000.00	9,843,480.00	10,062,000.00	6,838,020.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	2,500,000.00	2,500,000.00	1,075,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,336,000.00	4,947,560.00	5,045,000.00	3,534,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	981,630.00	1,500,000.00	0.00

Сантмаргаз сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00	650,000.00	640,000.00
210604	Урсгал засвар	2,336,000.00	3,965,930.00	2,895,000.00	2,894,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,794,000.00</b>	<b>2,052,000.00</b>	<b>1,400,000.00</b>	<b>835,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,794,000.00	2,052,000.00	1,400,000.00	835,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,582,700.00</b>	<b>2,581,344.00</b>	<b>2,582,500.00</b>	<b>1,944,654.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	700,000.00	700,000.00	564,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	200,000.00	199,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,000.00	79,000.00	79,000.00	48,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00	25,000.00	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	878,700.00	878,700.00	878,500.00	502,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	50,000.00	50,000.00	50,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	50,000.00	50,000.00	604.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	450,000.00	598,644.00	600,000.00	555,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>5,789,609.00</b>	<b>7,710,400.00</b>	<b>2,415,974.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,789,609.00	7,710,400.00	2,415,974.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>560,000.00</b>	<b>574,124.00</b>	<b>840,000.00</b>	<b>840,000.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>14,124.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	14,124.00	0.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>560,000.00</b>	<b>560,000.00</b>	<b>840,000.00</b>	<b>840,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560,000.00	560,000.00	840,000.00	840,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>450,674,400.00</b>	<b>466,255,000.00</b>	<b>452,616,700.00</b>	<b>565,561,906.50</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>450,674,400.00</b>	<b>466,255,000.00</b>	<b>452,616,700.00</b>	<b>565,561,906.50</b>
122005	Орон нутгийн төсвөөс	450,674,400.00	466,255,000.00	452,616,700.00	565,561,906.50
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>262,520.00</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>29.00</b>	<b>-</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	6.00	6.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>28.00</b>	<b>-</b>
620001	Удирдах ажилтан	-	-	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	22.00	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-	5.00	-

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Сантмаргаз сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>41,301,636.00</b>	<b>134,976,120.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>41,301,636.00</b>	<b>134,976,120.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	30,558,762.69	96,176,120.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,000,000.00	8,988,900.00
210101	Үндсэн цалин	2,000,000.00	0.00
210102	Нэмэгдэл	0.00	3,633,900.00
210104	Урамшуулал	0.00	5,355,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	663,000.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	663,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,934,690.00	4,500,000.00
210401	Бичиг хэрэг	117,920.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	1,259,570.00	4,500,000.00
210404	Ном, хэвлэл	1,215,100.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	342,100.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,089,308.69	26,283,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,089,308.69	21,016,200.00
210502	Хоол, хүнс	0.00	5,267,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,868,610.00	0.00
210604	Урсгал засвар	1,868,610.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	825,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	825,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,905,654.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,905,654.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,760,500.00	54,915,620.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,760,500.00	54,915,620.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,742,873.31	38,800,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,742,873.31	38,800,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,220,942.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	38,800,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,521,931.31</b>	<b>0.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,521,931.31	0.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	41,301,636.00	134,976,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	41,301,636.00	134,976,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,332,436.00	134,976,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,969,200.00	0.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сантмаргаз сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Г.Чулуунбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сантмаргаз сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 1/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан төр засгийн бодлого үйл ажиллагаатай нийцсэн, орон нутгийн онцлог, нөөц чадавхыг бүрэн дайчилсан судалгаанд суурилсан эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлж, хүмүүнлэг ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн, төрийн үйлчилгээг хүн амд ил тод шуурхай хүртээмжтэй хүргэх” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Үндэсний уламжлалыг сэргээж, эх хэл, түүх соёлоо дээдэлсэн монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлэх;
- Насан туршийн боловсрол олгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Урлаг соёлын арга хэмжээг цахим хэлбэрээр явуулах;
- Эмийн зохистой хэрэглээ, аюулгүй байдлыг ханган, эмийн сангийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах;
- Цар тахлын голомтод ажиллаж буй алба хаагчдыг эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах;
- Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжлийг дэмжих;
- Малын тэжээл болон хүнсний ногоо тариалагчдыг дэмжиж ажиллах;
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих;
- Гэрийн нөхцөлд боловсруулсан цагаан идээний төрлийг нэмэгдүүлж, сав баглаа боодолтой болгох;
- Малын дайвар бүтээгдэхүүн ашиглаж хагас боловсруулсан бүтээгдэхүүн хийх өрхийг дэмжих;
- Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг хагас, бүтэн жилд зохион байгуулах;
- Төрийн үйлчилгээг шуурхай, зарим төрлийн үйлчилгээ лавлагааг цахимаар хүргэх;
- Төрийн албан хаагчдыг мэргэжлээ дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжиж, ажлын байрны сургалтыг тогтмол хийх;
- Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн төлөөллөөр хийж хэрэгжүүлж, гүйцэтгүүлэх;

- Ан амьтны нутагшилтийн байдалд судалгаа тооллого хийж, зэрлэг амьтны амьдрах орчныг тэтгэх, биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх;
- Мал нядалгааны цэгт цэвэрлэгээ хийж, засвар үйлчилгээ хийж;
- Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах;
- Сургууль, цэцэрлэгийн орчинд замын тэмдэг, тэмдэглэгээ хийж нэмэгдүүлэх;
- Цэргийн болон улсын дайчилгааны төлөвлөгөөнд тодотгол хийх;
- Бэлчээрийн төлөв байдлыг фото мониторингийн аргаар тодорхойлох, сумын хатуу цэг тэмдэгтийн тооллого явуулж, кадастрын зургаар үйлчлэх;
- Нэгдсэн халаалтын системд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулж, их засвар үйлчилгээг хийлгүүлэх;
- Байгууллага бүр гамшгийн эрсдэлээ бууруулахад төсвийн 1 хувьтай тэнцэх сан байгуулах;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын Засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ийн үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сантмаргаз сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 3,367.81 сая төгрөгийн 1.5 хувь буюу 50.51 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 37.88 сая төгрөгөөр тус тус тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 252.42 сая төгрөг болж өмнөх оноос 90.24 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 55.40 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 34.50 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 0.42 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 162.10 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс бүрдсэн байна.

#### Авлага

Авлагын дансны үлдэгдэл 182.78 сая төгрөг болж өмнөх оноос 1.17 сая төгрөгөөр буурсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын барагдуулалт болон 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулахаар авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эрүүл мэндийн төв	216,229.20	17,817,996.76
Сум хөгжүүлэх сан	183,737,627.00	164,962,619.00
<b>Дүн</b>	<b>183,953,856.20</b>	<b>182,780,615.76</b>

#### Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 123.80 сая төгрөг болж өмнөх оноос 17.23 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвд “Ковид-19” цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

#### Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,106.05 сая төгрөг болж өмнөх оноос 111.39 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

#### Богино хугацаат өр төлбөр

Өглөгийн дансны үлдэгдэл 10.10 сая төгрөг болж өмнөх оноос 7.13 сая төгрөгөөр өссөн байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Засаг даргын тамгын газар	0.00	116,218.00
Эрүүл мэндийн төв	0.00	9,985,000.00
Хүүхдийн цэцэрлэг	2,977,174.00	0.00
<b>Дүн</b>	<b>2,977,174.00</b>	<b>10,101,218.00</b>

#### Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 6,654.97 сая төгрөг болж өмнөх оноос 12.20 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

#### Төсвийн шууд захирагчийн илрүүлэлт:

- Зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн;
- Мал амьтад данснаас 11 толгой ямаа дутагдсаныг хариуцах этгээдээр төлүүлээгүй;
- Зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй;
- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, НДШ-ийн зардал, албан томилолт зэргийг илүү тооцож олгосон, цалин хөлснөөс ХХОАТ-ыг суутгаагүй;
- Зардлын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй зэрэг нийт 21.79 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 2,128.44 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 223.96 сая төгрөгөөр нэмж, 2,352.40 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,352.40 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,218.41 сая төгрөгийг урсгал зардалд, 108.69 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 25.30 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,327.14 сая төгрөгийг улсын төсвөөс, 868.21 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15.55 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 64.64 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 0.00 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 76.86 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,301.50 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 850.50 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 8.57 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 64.64 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 27.12 сая төгрөг, нийт 2,252.33 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 100.07 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 27.11 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 27.11 сая төгрөгөөр давсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,214.91 сая төгрөг буюу 94.15 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 21.90 сая төгрөгийг сумын төсөвт, 23.81 сая төгрөгийг аймгийн төсөвт, 0.00 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.00 сая төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 0.00 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 73.67 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 78.56 сая төгрөгийн, нийт 152.23 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 152.23 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс, 131 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 0 мэдээллийг огт мэдээлээгүй, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Сантмаргаз сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалт бүхий зөвлөмж өгөгдөж 85.8 хувийн хэрэгжилттэй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

---

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар нийт 21.79 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

##### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа илрээгүй байна.

##### 4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

##### 4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.  
Үүнд:

###### 1. Хяналттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн, мал амьтад данснаас 11 толгой ямаа дутагдсаныг хариуцах этгээдээр төлүүлээгүй, зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, НДШ-ийн зардал, албан томилолт зэргийг илүү тооцож олгосон, цалин хөлснөөс ХХОАТ-ыг суутгаагүй, зардлын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.6. /хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх/, Засгийн Газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.13.7 /энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд/, 8 дугаар зүйлийн 8.4 /Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана/ гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн Аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	1.20	-	0.00	-	0.00	-	0.00	1	1.20
2	Засаг даргын тамгын газар	2	16.91	1	14.43	-	0.00	-	0.00	1	2.48
3	Ерөнхий боловсролын сургууль	3	21.55	-	0.00	1	0.31	2	21.24	-	0.00
4	Хүүхдийн цэцэрлэг	1	1.25	-	0.00	-	0.00	-	0.00	1	1.25
5	Соёлын төв	4	4.34	2	0.25	1	1.35	-	0.00	1	2.74
6	Эрүүл мэндийн төв	5	23.80	4	20.05	-	0.00	-	0.00	1	3.75
7	Орон нутгийн хөгжлийн сан	1	7.80	-	0.00	-	0.00	-	0.00	1	7.80
8	Төвлөрүүлэн захирагч	5	21.79	-	0.00	-	0.00	-	0.00	5	21.79
<b>Дүн</b>		<b>22</b>	<b>98.64</b>	<b>7</b>	<b>34.73</b>	<b>2</b>	<b>1.66</b>	<b>2</b>	<b>21.24</b>	<b>11</b>	<b>41.01</b>

### БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

ХЯНАСАН:

Г.ЧУЛУУНБААТАР

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

2022.03.25